

**Олон нийтийн радио ба телевизийн тухай Монгол Улсын хуулийн талаархи
САНАМЖ БИЧИГ**

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхийн төлөө дэлхий нийтийн 19-р зүйл байгууллагаас бэлтгэв.

2002 оны тавдугаар сар.

Орчуулсан Д. Цэрэнжав

Хянасан Г. Аким

Оршил

Монголын эрх баригчид олон нийтийн радио, телевизийн хуулийн төслийг боловсруулахдаа одоо засгийн газрын мэдэлд байгаа үндэсний хэмжээний Монголын радио, телевизийг олон нийтийн үйлчилгээтэй өргөн нэвтрүүлэгч болгож хувиргах зорилго тавьжээ. Хууль зүйн яамнаас иргэний нийгмийг төлөөлсөн янз бүрийн хувь хүмүүсийн оролцоотойгоор боловсруулсан уг хуулийн төсөл жил гаруйн өмнө бэлэн болсон ч хууль тогтоох байгууллагад өргөн бариагүй хэвээр байна.

Төр, засгийн байгууллагууд хэвлэл мэдээллийг өөрийн хяналт, мэдэлдээ байлгахыг хориглосон. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 4-р зүйлийг хэрэгжүүлэх шаардлагаас энэ хуулийн төсөл зарим талаар урган гарчээ. Үндэсний өргөн нэвтрүүлгийн байгууллагын, юуны өмнө программын хараат бус байдлыг хамгаалахад зориулсан заалтууд төсөлд оржээ. Жишээлбэл, 3.1-р зүйлд, олон нийтийн өргөн нэвтрүүлэг радио нэвтрүүлгийн байгууллага зөвхөн нийтийн эрх ашигт үйлчлэх ёстой гэж заасан бол 8.6-р зүйлд төрийн зүгээс программын бодлогод оролцох буюу нөлөөлөхийг хоригложээ. Бусад заалт нь жишээлбэл, тус зөвлөлийн гишүүний суудлыг баталгаатай болгох, улс төрийн өндөр албан тушаалтныг зөвлөлд оруулахгүй байх замаар төлөөлөн удирдах зөвлөлийг гаднын нөлөөллөөс ангижруулахыг хичээн тусгажээ. Ингээд үзэхэд уг хуулийн төслөөр одоогийн нөхцөл байдлыг сайн тал руу ихээхэн өөрчлөхөөр харагдаж байгаа нь нэлээд дэмжүүштэй юм. Үүний зэрэгцээ хуулийн төслийг зарчмын асуудлаар сайжруулах ёстой гэж 19-р зүйл байгууллага Үзсэн байна. Төлөөлөн удирдах зөвлөлийг томилох ажиллагаа үндсэндээ төрийн хяналтанд байна. Дараачийн онцгой чухал асуудал бол олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын үүрэг, зорилгыг хуулийн төсөлд нарийвчлан тодорхойлоогүй явдал юм. Энэ нь өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагааг хянах ба хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалахын аль алинд чухал ач холбогдолтой. Эцэст нь хэлэхэд, хуулийн төслөөр олон нийтийн радиог санхүүжүүлэх боломжтой олон эх үүсвэрийг жагсаасан хэдий ч чухам ямар тодорхой эх сурвалж олж авахыг баталгаажуулаагүй буюу олон нийтийн санхүүжилт хэрхэн бодитоор хэрэгжихийг нарийвчлан заасангүй.

Уг салбар дахь олон улсын үндсэн зарчмуудыг энэ санамж бичигт дэлгэн харууллаа. Бас хуулийн төслийн юу юун дээр 19-р зүйл байгууллага хамгийн ихээр санаа зовниж байгааг болон тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх саналыг хамтад нь толилуульж байна.

Олон улсын ба тулгуур хуулийн стандартууд

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (ХЭТТ) бол олон улсын хүний эрхийн тулгуур баримт бичиг бөгөөд олон улсын нийтлэг хуулийн адил бүх улс орнуудад үйлчилдэг. Уг тунхаглалд Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг дараах байдлаар томъёолжээ:

Хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг эдэлдэг, энэ эрх чөлөө нь аливаа хөндлөнгийн оролцоогүйгээр өөрийн үзэл бодолтой байх, аливаа мэдээлэл ба үзэл санааг хил хязгаарыг үл харгалзан хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрж хайх, хүлээж авах болон дамжуулах эрх чөлөөг багтаадаг.

Иргэний болон Улс төрийн Эрхийн Олон улсын Пакт (ИУТЭОУП) бол 1974 онд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ бөгөөд Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан эрхүүдийг хүндэтгэж үзэх үүргийг оролцогч улсуудад хуулийн хүрээнд хүлээлгэж байгаа юм. ИУТЭОУП-ийн 19-р зүйлд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19-р зүйлд заасантай тун адил томъёоллоор баталгаажуулсан байдаг. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаанууд бүс нутгуудын хүний эрхийн гурван гол системд, тухайлбал, Африкийн хүний ба ард түмнүүдийн эрхийн хартийн 9-р зүйл, Европын хүний эрх ба тулгуур эрх чөлөөг хамгаалах конвенцийн 10-р зүйл, Америкийн хүний эрхийн конвенцийн 13-р зүйлд тусгалаа олжээ.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 16.16-р зүйлд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дараах байдлаар баталгаажуулжээ.

Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэнэ:

.....

16) итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрхтэй. Жагсаал цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь ардчиллыг тогтооход тулгуур ач холбогдолтой учраас ИУТЭОУП болон олон улсын хүний эрхийн бусад гэрээгээр баталгаажуулсан эрхүүдийн дотроос хамгийн чухлын тоонд орно. 1946 онд болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хамгийн анхны чуулганаар баталсан 59 (1)-дүгээр тогтоолд "Мэдээллийн эрх чөлөө бол хүний тулгуур эрх бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тунхагласан бүх эрх чөлөөний тулгын чулуу мөн" гэжээ. Европын хүний эрхийн шүүжээс :

"Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө бол (ардчилсан) нийгмийн амин чухал үндэс суурь, тэр нийгмийн дэвшил ба хүн бүрийн хөгжлийн үндсэн нөхцөл болдог. Энэ нь зөвхөн таашаан хүлээж авдаг буюу аядуу төлөв агуулгатай төдийгүй төр засаг болон хүн амын аль ч хэсэг рүү давшилсан, цочоосон, төвөг учруулсан "мэдээлэл" ба "санаа бодолд" ч бас хамаатай. Ингэхийг шаарддаг олон эшт үзэл, бусдыг тэвчих, өргөн хүрээнд сэтгэх нөхцөлийг хангахгүйгээр "ардчилсан нийгэм" оршин тогтнох боломжгүй юм" хэмээн мэдэгдсэн байдаг.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх баталгаа нь юуны өмнө хэвлэл мэдээлэл, түүний дотор өргөн нэвтрүүлгийн ба олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллагуудад

хамаатай. Жишээлбэл, Америк дундын хүний эрхийн шүүх мэдэгдэхдээ "Хэвлэл мэдээлэл бол үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бодит зүйл болгодог" гэжээ. Европын хүний эрхийн шүүх "хууль ёсыг дээдэлдэг улс оронд хэвлэл мэдээлэл тэргүүлэх үүрэг"-тэйг заажээ. Хэвлэл мэдээлэл нь олон нийтийн эрх ашгийг илэрхийлсэн мэдээлэл, санаа бодлыг бүх нийтийн хүртээл болгодог учраас бүхэлдээ нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх тусгай хамгаалалтын үүрэг гүйцэтгэдэг. "Нэг талаас хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээлэл, санааг түгээх үүрэгтэй, нөгөө талаас олон нийт ч гэсэн тэдгээрийг авах эрхтэй". Эс тэгвэл хэвлэл мэдээлэл нь "олон нийтийн хяналтын хоточ нохой"-н үүргээ гүйцэтгэж чадахгүй.

Олон эшт үзэл

ИУТЭОУП-ын 2-р зүйлд "энэ тунхаглалд тодорхойлсон эрхүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоомж гаргах болон бусад арга хэмжээг авах" үүргийг улс орнуудад хүлээлгэжээ. Тэгэхлээр улс орнууд дээрх эрхүүдийг зөрчихөөс зайлсхийх төдийгүй бас үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангахад чиглэсэн нааштай алхмуудыг хийх ёстой гэсэн үг. Мөн чанартаа Засгийн газрууд олон янзын, хараат бус хэвлэл мэдээлэл хөгжиж, ингэснээр олон нийтийн мэдэх эрхийг гүйцэлдүүлэх тийм орчинг бүрдүүлэх үүрэгтэй болж байна.

Үзэл бодлоо илэрхийлэх ба хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах талаар улс орнуудын хүлээх үүргийн нэг чухал тал бол олон эшт үзэл бодлыг дэмжих, хэвлэл мэдээллийг бүх хүмүүст адил тэгш хүртээмжтэй байлгах явдал юм. Европын хүний эрхийн шүүхийн мэдэгдсэнчлэн "бүх нийтэд зориулсан мэдээлэл ба санаа бодлыг түгээх явдал олон эшт үзлийн зарчим дээр тулгуурлаагүй цагт амжилтанд хүрэхгүй.". Америк дундын шүүхээс тогтоохдоо, "үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний дагуу мэдээллийн харилцааны хэрэгслүүд хэнийг ч ялгаварлан гадуурхахгүйгээр бүгдэд нээлттэй байх ёстой тодруулбал, өмнө мэдээллийн хэрэгсэлд хүрэх боломжгүй нэг ч хувь хүн, эсвэл бүлэг хүмүүс байх ёсгүй" гэжээ.

Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн нэг үндсэн зарчим бол олон эшт үзлийг хангахад үйлчлэх явдал юм. Жишээлбэл, Германы Үндсэн хуулийн шүүхээс "олон эшт үзлийг дэмжих нь олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллагын хувьд үндсэн хуулийн дагуу хүлээх үүрэг юм" гэжээ. Чухам ийм шалтгаанаар олон улсын баримт бичгүүдэд олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллагууд ба олон эшт үзлийг хангахад тэдгээрийг оруулдаг хувь нэмрийг онцолсон байдаг. Эдгээр арга механизм болгоныг хууль тогтоомжинд хараахан оруулаагүй боловч олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллагын хувьд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд чухал чиг баримжаа болж байна.

Европын холбооноос баталсан "Гишүүн орнуудын засгийн газрын төлөөлөл ба консулуудын тухай тогтоол"-д янз бүрийн эх үүсвэрээс олон нийт рүү чиглэсэн мэдээллийн урсгалыг хангахад олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэхийг тодорхойлжээ. Бас олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллагууд нь ардчилал, нийгэм, соёлын хэрэгцээ шаардлага, хэвлэл мэдээллийн олон эшт үзлийг хадгалахад шууд үйлчилж байгааг тэмдэглэсэн байна. Үүний үр дүнд тэдгээр өргөн нэвтрүүлгийн байгууллагуудад төрөөс олгодог санхүүжилтыг Амстердамын гэрээний ерөнхий заалтуудаас хасчээ. Мөн ийм шалтгаанаар 1992 онд ЮНЕСКО-гийн ивээл дор баталсан Алма-Атагийн тунхаглалд улс орнуудыг олон нийтэд үйлчлэх радио, телевизийг дэмжихийг уриалжээ.

1994 онд Прага хотноо Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн бодлогын асуудлаар болсон Европын сайд нарын зөвлөлийн 4-р уулзалтаас гаргасан "Олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллагын ирээдүй" нэртэй 1-р тогтоолд тун ойролцоо агуулгатай зарчмуудыг сайшаасан. Уг шийдвэрт, олон нийтэд үйлчилдэг радио, телевиз нь хүний эрх, ардчилалд хичнээн чухал болох, өргөн хүрээтэй мэтгэлцээнийг олон нийтийн дунд

өрнүүлэх, зах зээлийн нөлөөлөлд автаагүй шинэлэг хөтөлбөр, орон нутгийн нэвтрүүлгийг дэмжихэд гүйцэтгэх үүргийг онцлон тэмдэглэжээ. Эдгээр амин чухал үүргээс үүдэн тус баримт бичигт гишүүн улсууд бүх хүмүүст хүртээлтэй, олон нийтэд үйлчилдэг, өргөн цар хүрээтэй радио, телевизийн ядахдаа нэг байгууллагыг баталгаатай ажиллуулахыг санал болгосон билээ.

Хараат бус байдал ба санхүүжилт

Олон эшт үзэл, мэдээлэл, санааг олон нийтэд, тухайлбал хэвлэл мэдээллээр чөлөөтэй хүргэх талаар улс орнуудын хүлээсэн үүрэг нь өргөн нэвтрүүлгийн, үүний дотор нийтийн эх үүсвэрээс санхүүжүүлдэг байгууллагуудын үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхөд хүргэх учиргүй. Энэхүү шаардлага нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг лиценз зөвшөөрлөөр дамжуулан ямар нэгэн байдлаар хязгаарлах нь олон улсын хуулиар тогтоосон тийм хязгаарлалтад нийцэж байх ёстой гэж тогтоосон Европын хүний эрхийн шүүхийн өмнөх практикаас урган гарчээ. Тухайлбал, ямарваа хязгаарлалтууд нь хууль эрх зүйн цөөн үндэслэлийн аль нэгийг хангасан, бас тэгээд зайлшгүй шаардлагатай байх ёстой. Үүнтэй адилаар, Европын хил дамнасан телевизийн конвенцийн оршилд "Мэдээлэл ба санаа бодол чөлөөтэй урсах болон өргөн нэвтрүүлгийн байгууллагын хараат бус байдлын зарчмуудыг дээдлэхээ баталж байна" хэмээн тунхаглажээ.

Эдгээр баталгаануудын чухал нөхцөл бол өргөн нэвтрүүлгийн салбарт тодорхой зохицуулалт явуулдаг болон бусад эрх мэдэлтэй байгууллагууд, жишээлбэл, өргөн нэвтрүүлгийн хэрэг эрхэлсэн төрийн байгууллагууд, төрөөс санхүүжилттэй радио, телевизийн зөвлөлүүд хараат бус байх ёстой. Энэ зарчмыг олон улсын хэд хэдэн баримт бичигт тов тодорхой зааж өгсөн юм.

Эдгээрээс магадгүй хамгийн чухал нь Европын зөвлөлийн Сайд нарын хорооноос баталсан "Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагааны хараат бус байдлын баталгаа"-ны тухай R (96)10 тоот зөвлөмж байж болох юм. Зөвлөмжийн нэр нь хүртэл олон нийтэд үйлчилдэг радио, телевизийн хараат бус байдалд хичнээн их ач холбогдол өгч байгааг тод томруун илтгэнэ. Зөвлөмжинд тэмдэглэснээр бол хяналт тавих, удирдах байгууллагуудын эрх мэдлийг хуулиар нарийвчлан тодорхойлох ёстой. Эдгээр байгууллага нэвтрүүлгийн агуулгад нөлөөлөх эрхгүй. Удирдах байгууллагыг бий болгохдоо, олон эшт үзэл бодлыг хангах үүднээс томилгоог нээлттэй явуулах, татан буулгахгүй байх баталгааг өгөх, мөн сонирхлын зөрчлийн талаархи дүрэм журам гаргах замаар тэдний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхөөс аль болохоор сэргийлэх зарчмыг баримтлах ёстой.

ЮНЕСКО-гийн ивээл дор баталсан хэд хэдэн Тунхаглалд олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн хараат бус байгууллагын ач холбогдлыг онцлон тэмдэглэлээ. 1996 оны САНА-гийн Тунхаглал нь олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагыг зөвхөн хараат бус тохиолдолд л дэмжихийг олон улсын хамтын нийгэмлэгт хандан уриалаад, ийм хараат бус байдлыг баталгаажуулахыг улс орон тус бүрт бас уриалжээ. 1997 оны Софигийн Тунхаглалд төрийн эзэмшлийн өргөн нэвтрүүлгийн байгууллагыг хараат бус редакци ба хараат бус хяналтын байгууллагатай, жинхэнэ олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллага болгон хувиргах шаардлагатай байгааг тэмдэглэсэн юм.

Дээр дурдсанчлан, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн бодлогын асуудлаар болсон Европын сайд нарын зөвлөлийн 4-р уулзалтаар "Олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн ирээдүй" гэсэн 1-р тогтоолд хараат бус удирдах зөвлөл, редакцийн хараат бус байдал, зохистой буюу хангалттай санхүүжилтыг тусгасан эдгээр зарчмуудыг дахин баталлаа. Ийм зөвлөмжүүд, ялангуяа засгийн газраас хараат бус, үүний дотор санхүүгийн хувьд хараат бус байдлыг үр дүнтэй хангах тухай зарчмууд нь хэвлэл мэдээллийн асуудлаар болсон Европын зөвлөлийн Парламентийн Ассамблей болон Сайд нарын уулзалтын хэд хэдэн тогтоол, зөвлөмжүүдэд давтагдаж байлаа.

19-р зҮйл байгууллагаас өргөн нэвтрүүлэгтэй холбоотой олон улсын хууль, практикаас урган гарсан хэсэг зарчмуудыг боловсруулж "Агаарын долгионыг нээлттэй болгох нь: Үзэл бодлоо илэрхийлэх болон өргөн нэвтрүүлгийг зохицуулах зарчмууд" нэрээр гаргажээ. 34-р зарчимд Засгийн газрын ба төрийн мэдлийн өргөн нэвтрүүлгийн байгууллагыг олон нийтэд үйлчилдэг болгох шаардлагатайг тэмдэглэсэн бол 35-р зарчимд эдгээр байгууллагуудын хараат бус байдлыг хамгаалах хэрэгтэйг онцолжээ. 35.1-р зүйлд, Удирдлагын зөвлөл шиг бие даасан бүтцийн зүгээс хяналт тавих гэх мэтээр олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын хараат бус байдлыг хангах арга замуудыг дурджээ. Ийм зөвлөлийн өөрийгөө удирддаг, хараат бус зарчмыг дараах арга замаар баталгаажуулахаар хуулинд оруулах ёстой.

1. Энэ бүтцийг бий болгохоор заасан холбогдох хууль тогтоомж, хэрвээ боломжтой бол Үндсэн хуульд уг асуудлыг нарийвчлан тодорхой зааж өгөх
2. Зорилго, эрх мэдэл ба хариуцлагыг хуулинд тодруулж тусгах
3. Зөвлөлийн гишүүдийг томилох асуудлаар дүрэм журам гаргах
4. Олон намын төлөөллийг оруулах замаар олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг хангах
5. Редакцийн хараат бус байдлыг хүндэтгэх
6. Санхүүжилтыг дүрэм журамтай болох

Эдгээртэй төстэй зарчмууд үндэсний шүүхүүдээр шийдэгдсэн нэлээд хэрэгт тусгалаа олжээ. Жишээлбэл, Шри Ланкийн Дээд шүүхээс өргөн нэвтрүүлгийн хуулийн төслийг хэлэлцээд энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг үндсэн хуулиар баталгаажуулсантай зөрчилдөж байна гэсэн шийдвэр гаргасан. Хуулийн төслөөр бол яамны сайд нь зохицуулах эрх мэдэл бүхий байгууллагын захирлуудын зөвлөлийг томилоход шийдвэрлэх эрхтэй байжээ. Уг шүүхээс тэмдэглэхдээ: Хүмүүсийн бодол санаанд хамгийн хүчтэй нөлөөлдөг хэмээн бүгд хүлээн зөвшөөрдөг электрон мэдээллийн хэрэгслийг зохицуулах байгууллагын хараат бус байдлыг эрх баригчид хангасангүй" гэжээ.

Үүний нэгэн адил Ганийн дээд шүүхээс заахдаа: "Төрийн эзэмшлийн олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд бол улс үндэстний баялаг юм. Тэд төр засаг гэж нэрлэдэг хийсвэр зүйлд биш, төрийн эрхийг барьж буй засгийн газарт юм уу түүнийг бүрдүүлсэн намуудад биш, харин нийт иргэдэд харьялагдана. Хэрвээ үндэсний энэхүү баялаг засгийн эрхийн төлөө тэмцэж буй аль нэг буюу хэдэн намын дуу хоолой болчихвол ардчилал хоосон зүйл болно" гэжээ.

Дээр тавигдсан зарчмууд нь удирдах бүтцийн хараат бус байдал, мөн үүнтэй холбоотой боловч арай өөр агуулгатай олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын редакцийн хараат бус байдлыг хуулиар болон практик дээр баталгаажуулах ёстой гэсэн хоёр санааг илэрхийлж харуулж байна. Мөн үүнийг 19-р зҮйл байгууллагын Зарчмуудын 35.3-т тусгаж "Хараат бус удирдах байгууллага нь өдөр тутмын шийдвэр гаргах үйл ажиллагаа, ялангуяа нэвтрүүлгийн агуулгад хутгалдах ёсгүй, редакцийн хараат бус байдлыг хүндэтгэж, урьд байсан цензурийг хэрхэвч тулгахгүй" гэжээ. Удирдах байгууллагаас ерөнхий чиглэл ба бодлогыг тодорхойлж болно, гэхдээ туйлын онцгой нөхцөл үүсээгүй л бол хөтөлбөрийн талаар шийдвэр гаргахад оролцох ёсгүй".

Олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжууд нь нэвтрүүлгийн хуваарь, хөтөлбөр, мэдээ ба бусад хэд хэдэн асуудлаар редакцийн хараат бус байдал, бүтцийн хувьд өөрийгөө удирддаг байхыг баталгаажуулах ёстойг тэмдэглэсэн Европын зөвлөлийн R (96)10 тоот зөвлөмжийн 1-р зүйлд дээрх заалтууд тусгалаа олсон юм. Удирдлага нь өдөр тутмын ажлаа дангаараа хариуцах ёстой бөгөөд жишээлбэл, хяналтын байгууллага болон шүүхийн өмнө хүлээх хариуцлагыг зааглах зэрэг аргаар улс төрийн нөлөөллөөс хамгаалагдах ёстой гэсэн дүгнэлтэд хүрч байгаа юм. Тэрхүү зөвлөмжийн 20-22-р зүйлүүдэд тэмдэглэсэнээр мэдээллийн нэвтрүүлгүүд баримтыг бодитой тусгаж, янз бүрийн санал бодлууд чөлөөтэй гарч ирэхийг хөхүүлэн дэмжих ёстой. Олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн

байгууллагуудаас зөвхөн маш онцгой нөхцөл байдалд л ямар нэгэн мэдээллийг дамжуулахыг шахаж шаардах ёстой.

Үүнтэй нэгэн адилаар, засгийн газрын хатуу хяналтаас ангид санхүүжилттэй нөхцөлд л жинхэнэ хараат бус байдлыг хангаж чадах ба дээр дурдсан олон улсын стандартууд энэ зарчмыг илэрхийлж байгаа юм. Дээрээс нь, олон нийтэд үйлчлэх өргөн нэвтрүүлэг эрхлэгчид зөвхөн хангалттай санхүүжилт авсан нөхцөлд л хүлээсэн үүргээ биелүүлж чадна. Европын зөвлөлийн R (96)10 тоот зөвлөмжийн 17-19-р зүйлд, олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллагын санхүүжилт нь тэдний өмнө тавьсан зорилттой дүйцсэн, бас найдвартай, ил тод байх талаар дурджээ. Санхүүжүүлэх арга нь олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгч байгууллагыг хөндлөнгийн нөлөөлөлд автахад хүргэх ёсгүй. Жишээлбэл, редакцийн хараат бус, өөрийгөө удирдах зарчмыг алдагдуулах учиргүй.

19-р зүйл байгууллагын 36-р Зарчимд санхүүжилтийн асуудлыг хөндөхдөө "Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагууд нь хүрэлцэхүйц хэмжээгээр, ингэхдээ төсөв мөнгөөр дамжуулан хөндлөнгийн шахалт дарамтад орохоос хамгаалагдсан аргаар санхүүжигдэх ёстой" гэжээ. Үүнтэй төсөөтэйгээр, Италийн үндсэн хуулийн шүүх "Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг Үндсэн хуулиар баталгаажуулсан учраас Засгийн газраас олон нийтийн нэвтрүүлэг эрхэлдэг байгууллагууд үүргээ гүйцэтгэхэд хангалттай хөрөнгө нөөцийг гаргах үүрэгтэй" хэмээн шийдвэрлэсэн байна.

Тодорхой асуудлууд

Хараат бус байдал

Дээр тэмдэглэсэнчлэн, Монголын олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн төсөлд үндэсний өргөн нэвтрүүлгийн байгууллагын хараат бус байдлыг хамгаалах зорилготой хэд хэдэн нөхцлийг оруулжээ. 3.1-р зүйлд түүнийг зөвхөн нийтийн эрх ашигт үйлчлэх үүрэгтэй, 3.3-р зүйлд үйл ажиллагаа нь хараат бус байх зарчимд тулгаруулах ёстой гэжээ. Хуулийн төслөөр бол Төлөөлөн удирдах зөвлөлд өргөн эрх олгосон бөгөөд 4.4-р зүйлд Засгийн газрын зүгээс зөвхөн онцгой нөхцөлд төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрт хориг тавьж болохыг зөвшөөрсөн байна.

Бүтэц

Нэлээд тохиолдолд хараат бус байдлыг алдагдуулахаар болжээ. Олон нийтийн радио, телевизийн бүтэц, зохион байгуулалт нь еерее Засгийн газрын хатуу хяналтанд оруулж байгаад гол асуудал оршино. 4.2-р зүйлд зааснаар бол үүсгэн байгуулагч нь төр өөрөө байх ба түүний өмнөөс үүсгэн байгуулах шийдвэрийг Засгийн газар гаргах ёстой ажээ. Үүнээс болж тухайн өргөн нэвтрүүлгийн байгууллагын олон нийтийн гэсэн мөн чанар алдагдах, эсвэл нь зөвхөн үүсгэн байгуулаад л бас зогсоож чадах эсэх нь тодорхойгүй үлдсэн байна.) 4.3-р зүйлээр бол Засгийн газраас олон нийтийн радио, телевизийн дүрмийг батлах эрхтэй. Цаашилбал, олон нийтийн радио, телевизийн хувьцааг Засгийн газар 100 хувь эзэмшинэ (6.2-р зүйл). Эцэст нь 18.3-р зүйлд төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавих хянан шалгах зөвлөл байх тухай заажээ. Энэ нь ямар учиртай байгууллага болох, ямар үүрэгтэй, бас чухам яагаад хэрэгтэй гэдэг нь бүдэг байна.

Олон улс оронд олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага нь олон нийтийн хувьцаат компани байдаг, гэхдээ төрийн эсвэл засгийн газрын шууд мэдэл, хяналт, емчинд байх шаардлагагүй, олон нийтийн шинж чанартай субъект юм. Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага нь Монголын хууль тогтоомжинд нийцсэн бүтэцтэй байх ёстой нь мэдээж, үүнийг зэрэгцээ тэр бүтэц нь хараат бус байдлыг хангах чадвартай байх учиртай. Засгийн газрын хувьд наад зах нь олон нийтийн зарим субъектын мэдэлд байх ёстой хувьцааг

эзэмших нь зохисгүй гэдэг нь тов тодорхой. Дүрмийн тухайд гэвэл, түүнийг удирдах зөвлөлөөс баталдаг, харин хурлыг зарлах, ирц бүрдэлт зэрэг зарчмын асуудлыг хуулинд зааж өгдөг жишиг тогтжээ.

Зөвлөмжүүд

- Олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэх байгууллага нь Засгийн газраас аль болох хараат бус байхын тулд эрх зүйн өөр хэлбэрийг эрж хайх хэрэгтэй. Ялангуяа Засгийн газар нь яавч үүсгэн байгуулагч байж олон нийтийн өргөн нэвтрүүлгийг байгуулж таарахгүй бөгөөд бас бүх хувьцааг эзэмших ёсгүй.
- Дүрмийг Засгийн газар биш, Төлөөлөн удирдах зөвлөл батлах талаар хуулинд тусгах шаардлагатай. Харин зөвлөлийн хуралдаантай холбоотой зарчмын асуудлыг шууд хуулиндаа тусгавал зүйтэй.
- Хянан шалгах зөвлөлийн хяналтын үүргийг эсвэл бүрмөсөн цуцлах, эсвэл түүний мөн чанар ба эрх үүргийг хуулинд маш тодорхой зааж өгөх ёстой.

Төлөөлөн удирдах зөвлөлийг томилох нь

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн төслийн нэг ноцтой асуудал бол удирдах зөвлөлийн гишүүдийг томилох журам юм. 12-р зүйлд хараат бус төлөөлөн удирдах зөвлөл байгуулах тухай дурджээ. 13.3-р зүйлд зааснаар, энэхүү зөвлөлийн өсөн гишүүнийг Ерөнхий сайд томилно, ингэхдээ гурван хүйн Парламент, Ерөнхийлөгч ба Засгийн газар тус бүр нэр дэвшүүлэх ажээ. Хэдийгээр томилох үйл явцад төр, засгийн өөр өөр байгууллагыг оролцуулж байгаа ч эцсийн дүндээ одоогийн Монгол ба бусад олон орных шиг нэг намынхан давамгайлах болно. Үүнээс гадна энэ томилгоог нээлттэй явуулах, иргэний нийгмийн оролцоог хангах нөхцөл алга байна.

Сайд нарын хорооны Зөвлөмжинд удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохтой холбоотой горимыг нарийвчлан тодорхойлж, хуулинд дараах байдлаар баталгаажуулах ёстойг тайлбарласан билээ. Үүнд:

- Нээлттэй ба олон эшт үзэлд нийцсэн аргаар томилох
- Нийгмийн ашиг сонирхлуудыг ерөнхийд нь нэгтгэж төлөөлүүлэх
- Хуулинд заасан онцгой нөхцөл байдал үүсээгүй бол тэднийг томилсноос өөр хүн, байгууллага ямар нэгэн мандат зөвшөөрөл, эсвэл аливаа зааварчилгаа өгөхгүй байх.
- Хянаж шалгах эрх мэдэл бүхий байгууллагаас тэднийг үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон, эсвэл үүргээ гүйцэтгэхээс зайлсхийсэн гэж зохих ёсоор батлаагүй бол тэднийг томилсноос өөр хүн, байгууллагаас бүрэн эрхийнх нь хугацаанд халахгүй, үйл ажиллагааг нь зогсоохгүй, солихгүй байх.
- Хянаж байгууллагад гүйцэтгэж буй үүрэгтэйгээ ашиг сонирхлын хувьд зөрчилдөж мэдэх хэвлэл мэдээлэл болон түүнтэй холбоотой салбарын аж ахуйн нэгж, байгууллагын өмнө үүрэг хүлээх, тэндээс хөлс мөнгө авах, ашиг сонирхлоор холбогдох явдлыг шууд ба шууд бусаар гаргах ёсгүй.

Гэтэл хуулийн төсөлд санал болгосон томилгооны горим нь дээрх шаардлагуудыг хангаж чадахгүй нь илт байна.

Уг нь томилгоог Ерөнхий сайд шиг хувь хүмүүс биш, харин хууль тогтоох байгуулага зэрэг олон намын оролцоотой бүтэц хариуцвал зохистой байхсан. Цаашилбал, томилох эрх мэдлийг зөвхөн Засгийн газар, Ерөнхийлөгч зэрэг улс төрийн тоглогчдод олгох ёсгүй. Иргэний нийгмийн байгууллагууд ч гэсэн зөвлөлийн гишүүдэд нэр дэвшүүлж хууль тогтоогчдоор батлуулахаар санал болгох эрхтэй байх ёстой.. Бас хийж буй алхмуудыг нийгмийн гишүүдэд мэдүүлж байхын тулд томилох горимыг нээлттэй байлгахыг хуулинд заамаар байна. Ер нь олон нийтийг оролцуулах тодорхой нөхцлүүдийг зайлшгүй бүрдүүлэх шаардлагатай болжээ. Үүнд, нэр дэвшигчдээс шигшигдэж үлдсэн хүмүүсийн нэрсийн жагсаалтыг хэвлэлд нийтэлж, олон нийтийн зүгээс тайлбар хийх, эсвэл өөр зарим арга механизм байж болно.

Энэ салбар дахь олон улсын стандартад нийцсэн хуулийн сайн жишээ бол 1999 онд батлагдсан Өмнөд Африкийн өргөн нэвтрүүлгийн хууль бөгөөд удирдах зөвлөлийг дараах байдлаар томилохоор заажээ.

13. Зөвлөлийн гишүүд

1) Зөвлөлийн орон тооны бус (зөвлөх) 12 гишүүнийг Үндэсний Ассамблейн зөвлөмжинд үндэслэн Ерөнхийлөгч томилно.

(2) Зөвлөлийн орон тооны бус гишүүдийг томилох арга нь дараах зарчмыг хангах ёстой:

(a) Томилох үйл явцад олон нийтийг оролцуулах

(b) Ил тод ба нээлттэй байх

(c) Энэ хуулийн зорилго, зарчмыг үндэслэн нэр дэвшигчдээс шигшиж үлдээсэн хүмүүсийн нэрсийн жагсаалтыг нийтлэх

Олон нийтийн радио, телевизийн тухай Монголын хуулийн төсөлд нийтлэлийн /нэвтрүүлгийн/ бодлогыг тодорхойлоход зөвлөх үүрэгтэй Нийтлэлийн бодлогын зөвлөл гэж байхаар оржээ (8.2-р зүйл). 8.2-р зүйлд дурдсанаар, Нийтлэлийн бодлогын зөвлөл нь зөвхөн зөвлөх үүрэгтэй. Гэтэл 8.4-р зүйлд Төлөөлөн удирдах зөвлөл нь түүний зөвлөмжийг хүлээж авах ёстой гэжээ. Үүнийг тодруулах шаардлагатай. Нэвтрүүлгийн асуудлыг хариуцсан тусдаа бүтцийг бий болгох нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус байдал хангалтгүй байгааг зарим талаар нөхөж болох юм, гэхдээ энэ чухал байгууллагыг улс төрийн нөлөөллөөс хамгаалах асуудал чухал хэвээрээ үлдлээ.

13.4 ба 13.5-р зүйлд Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд сонгогдох хувь хүний өмнө тавигдах хэд хэдэн шаардлага, үүнд зохих туршлагатай, ял шийтгэлд хүлээж яваагүй, сонгуульт буюу намын албан тушаалтан биш, бусад радио, телевизэд ажилладаггүй байх зэрэг шаардлагыг жагсаажээ. "Тохирохгүй хүмүүсийн тухай"- заалтууд тун нааштай зүйл болжээ. Харин сонирхлын зөрчлийн холбогдолтой нөхцлүүдийг дээрээс нэмж оруулах талаар бодож үзүүштэй. Ингэснээр өргөн нэвтрүүлэг ба харилцаа холбооны салбарт томоохон ашиг сонирхол бүхий хувь хүмүүс уг зөвлөлд томилогдохоос сэргийлэх учиртай юм. Үүнтэй нэгэн адил, эрүүл мэнд муудсан, гэмт хэрэгт холбогдсоноос бусад тохиолдолд гишүүдийг удирдах зөвлөлөөс гаргахыг хориглосон 13.6-р зүйл бол хараат бус байдлыг нь хангах чухал арга юм. Зөвлөлийн гишүүнийг халах үндэслэл дээр бас 13.5-р зүйлд заасан зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг зөрчсөн тохиолдлыг нэмэх асуудлыг авч үзүүштэй.

Зөвлөмжүүд:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Ерөнхий сайд зэрэг хувь хүмүүс бус, харин хууль тогтоох байгууллага томилох ёстой.
- Нэр дэвшүүлэх эрхийг дан ганц төр, засгийн байгууллагууд эдлэх ёсгүй. Бас иргэний нийгмийн байгууллагууд зөвлөлийн гишүүнд томилуулахаар нэр дэвшүүлж холбогдох байгууллагад нь хандах эрхтэй байх ёстой.
- Томилох үйл явц ил тод, нэр дэвшигчдийн талаар олон нийт мэдэж танилцах бололцоог хангасан байх ёстой.
- Нийтлэлийн бодлогын зөвлөл ямар үүрэг гүйцэтгэхийг тодорхой болгох

- "Сонирхлын зөрчилтэй хүмүүс"-ийн тухай заалтуудад сонирхлын зөрчлийн асуудлыг нэмэх хэрэгтэй
- "Сонирхлын зөрчилтэй хүмүүс"-ийн тухай заалтуудын шаардлагыг хангахаа больсон хүмүүсийг зөвлөлөөс хасдаг байх

"Заавал нэвтрүүлэх" шаардлагууд

Хуулийн төслийн 10-р зүйлд үндэсний өргөн нэвтрүүлгийн байгууллагууд байгалийн болон нийтийг хамарсан гамшгаас сэргийлэх тухай шуурхай мэдээлэл, энэ талаархи Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ны даргын мэдэгдлийг нэвтрүүлэхийг үүрэг болгожээ. Ийм хэм хэмжээ байх үндэстэй гэдэг нь ойлгомжтой боловч үнэн хэрэгтээ аль аль нь хэрэггүй төдийгүй урвуулан ашиглах боломжийг нээж өгч байгаа юм. Учир нь хариуцлагаа ухамсарладаг олон нийтийн өргөн нэвтрүүлгийн аль ч байгууллага олон нийтэд амин чухал мэдээллийг заавал шаардуулахгүйгээр дамжуулах болно. Дэлхийн улс орнуудын туршлагаас үзэхэд олон нийтийн, эсвэл хувийн өргөн нэвтрүүлгийн байгууллагууд ямар нэгэн үүрэг даалгавар аваагүй ч ноцтой үйл явдал ба байгалийн гамшгийг хангалттай нэвтрүүлдэг. Ийм ҮҮргийг өргөн нэвтрүүлэгт хүлээлгэсэн улс орон маш ховор. Тэгэх тухай үүрэг даалгавар өгөх нь ч маш ховор. Дээрх сэдвийг олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага орхигдуулсан бол Төлөөлөн удирдах зөвлөл энэ асуудлыг анхааралдаа авах болно.

Иймэрхүү заалт байгаа тохиолдолд урвуулан ашиглах боломж нээгддэг. Тодорхой албан тушаалтнууд үүнийг огт өөр нөхцөлд зүй бусаар ашиглаж болно. Төсөлд онцгой нөхцөл байдлын талаар нарийвчлан тодорхойлоогүй учраас маш өргөн хүрээнд ашиглаж болзошгүй юм. Бодит амьдрал дээр онцгой байдал маш ховор үүсдэг. Ер нь олон нийтийн хувьд онцгой байдлын талаар өөрт хэрэгцээтэй мэдээллийг олж авах нь илүү чухал байдаг бөгөөд улс төрчид энэ талаар юу ярих нь төдийлөн чухал биш.

Зөвлөмж:

- 10-р зүйлийг уг хуулийн төслөөс хасах нь зүйтэй.

Санхүүжилт

Хуулийн төслийн 17-р зүйлд олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага нь санхүүжилтээ улсын төсвөөс, лицензийн төлбөр (нэвтрүүлгийн хураамж)-өөс, зар сурталчилгаанаас, хандиваас, тоног төхөөрөмж түрээслэхээс, нэвтрүүлгийн төлбөрөөс болон хуулинд заасан бусад эх үүсвэрээс бүрдүүлж болохыг зөвшөөрчээ. 19-р зүйлд зар сурталчилгаа нь тухайн өдрийн нэвтрүүлгийн нийт цагийн 5 хувиас хэтрэхгүй байхаар хязгаарлалт тавьсан байна.

Хараат бус байдлаа хангаж хүлээсэн үүргээ биелүүлэх чадвартай байхын тулд олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллагууд хүрэлцэхүйц хэмжээгээр санхүүжиж төсвийг нь дур зоргоороо хасах явдлаас хамгаалагдсан байх ёстой. Сайд нарын хорооны Зөвлөмжинд ингэж дурдсан байна:

Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын санхүүжилтийн зохицуулалт нь гишүүн улсуудад тогтвортой дагаж мөрдөх, хэрвээ шаардлага гарвал шинээр бий болгох зохистой, найдвартай бөгөөд ил тод санхүүжилтын зарчим дээр тулгуурлах учиртай. Энэ нь олон нийтэд үйлчлэх өргөн нэвтрүүлгийн байгууллагуудын хувьд үүрэг зорилгоо биелүүлэхэд нь зайлшгүй шаардлагатай юм.

Төслийн 7-р зүйлд олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын санхүүжилтийн Засгийн газрын бус эх үүсвэрийн хүрээг тодорхой заасангүй. Жишээлбэл, 17-р зүйлд хараат бус байдлыг хангах үүднээс хамгийн тохиромжтой эх үүсвэр болох нэвтрүүлгийн хураамжаас өргөн нэвтрүүлэг эрхэлдэг байгууллагын орлогыг бүрдүүлэхийг баталгаажуулсан бол зүйтэй байхсан. Улсын төсвөөс санхүүжих нь улс төрийн нөлөөлөлд автахад хүргэдэг талаар их шүүмжилдэг боловч нэвтрүүлгийн хураамж ба зар сурталчилгаанаас хангалттай санхүүжилт ордоггүй нөхцөлд чухал энэ нь авах хэрэгтэй эх үүсвэр байж болох талтай юм. Улсын төсвөөс шууд санхүүжилтыг үргэлжлүүлэх шийдвэр гаргахын өмнө бусад эх үүсвэрүүдийн талаар сайтар бодож үзэх хэрэгтэй. Бусад өргөн нэвтрүүлгийн байгууллагын төлж буй үйл ажиллагааны болон долгион ашиглалтын лицензийн орлогоос хүртэх нь олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын хувьд өөр нэг боломж юм. Эсвэл энэ хуулиар төрөөс авсан дотацийг ашиглах явдлыг зохицуулж, тухайлбал, зөвхөн дамжуулах тоног төхөөрөмжийн ашиглалт зэрэг нэвтрүүлгийн бус зардалд зориулж болох юм. Энэхүү арга шилжилтийн үеийн ардчилал бүхий хэд хэдэн оронд хэрэгжиж байгаа ба дээрээс шууд санхүүжүүлэх замаар улс төрийн хяналт тавихыг хязгаарлаж байгаа юм.

Зар сурталчилгааны цагийг 5 хувиар хязгаарласан нь хэт хатуурхсан хэрэг юм. Өнөөдөр дэлхий дахинд олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчид зар сурталчилгааг багтаасан холимог эх үүсвэрүүдийг ашигладаг ч ийм хатуу хязгаарлалт бараг үгүй. Зар сурталчилгааны орлогын хувь хэмжээ нь олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгч байгууллага олон нийтэд үйлчлэхэд нь нөлөөлөхүйц тийм өндөр байх ёсгүй, гэхдээ бас түүний хэвийн ажиллах боломжийг хязгаарлах учиргүй. Жишээлбэл, Европын жил дамнасан телевизийн тухай конвенцид өргөн нэвтрүүлгийн бүх байгууллагын зар сурталчилгаанд 20% гэсэн хязгаар тогтоосон ба олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгч байгууллагад наад зах нь энэ тоо хэмжээний тэн хагасыг зөвшөөрдөг байна.

Зөвлөмжүүд

- 17-р зүйлд олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын санхүүжих Засгийн газрын бус эх үүсвэрийг илүү тодорхой зааж өгөх шаардлагатай бөгөөд нэвтрүүлгийн хураамжаас тогтвортой санхүүжилт хийгдэхийг баталгаажуулах нь зүйтэй
- Улсын төсвөөс шууд дотац олгохоос өөр санхүүжилтийн ямар эх үүсвэр байгааг авч үзэх. Нэвтрүүлэг бүтээхэд зарцуулах аливаа шууд санхүүжилтийг хязгаарлах ёстой.
- 19-р зүйлд зар сурталчилгааны цагийг таван хувиар хязгаарласныг олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын оршин тогтнох чадварыг сайжруулах үүднээс өндөр болгох шаардлагатай.

Хариуцлагын механизм

Хуулийн төсөлд заахдаа олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгч байгууллага жилийн ажлаа тайлагнах (12.2-р зүйл), мөн хараат бус аудитораар баталгаажуулсан санхүүгийн тайлан гаргахыг үүрэг болгожээ (18-р зүйл). Энэ хоёрыг жилийн тайлангийн агуулга ямар байх тухай нэгбүрчилсэн жагсаалтаар дэлгэрүүлэх, ингэснээр Төлөөлөн удирдах зөвлөлийн дүр зоргоороо ажиллахыг зарим талаар хязгаарлаж зохистой болгох юм.

Хуулийн төсөлд 9-р зүйлд нэвтрүүлгийн агуулга ямар шаардлагад нийцэх ёстойг заасан бөгөөд бас 3-р зүйлд заримыг дурджээ. Эхнийхэд нь радио телевизийн нэвтрүүлэг үнэн бодитой, мэргэжлийн түвшинд хүрсэн, нийгмийн аюулгүй байдлыг эрхэмлэсэн, олон эшт үзлийг хангасан, баримтыг гуйвуулаагүй, редакцийн хараат бус байдлыг сахисан, үндэснийхээ уламжлалыг хөгжүүлсэн, тэгээд хуулиар хориглосон материал оруулаагүй байх ёстойг шаарджээ. Энэ бүхэн зөв зүйтэй бөгөөд нэвтрүүлгийн шаардлагыг нарийвчилсан тодорхойлох нь хэд хэдэн чухал ач холбогдолтой. Энэ нь олон нийт ба Төлөөлөн удирдах зөвлөлийн аль алинд олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага юу хийх ёстой талаар

мэдрүүлнэ. Нэвтрүүлгийн ерөнхий бодлогыг тодорхойлох боломжийг хууль тогтоогчдод олгоно.

19-р зүйл байгууллагын Зарчмууд-ад олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын нэвтрүүлэгт тавигдаж болох шаардлагуудын жагсаалтыг гаргаж 37-р зүйлдээ оруулжээ.

Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын үүрэг нь Засгийн газрын санхүүжилттэй нягт холбоотой бөгөөд хуулиар нарийвчлан тодорхойлсон байх ёстой. Олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчид нь мэдээлэл, боловсрол, соёл урлаг, зугаа цэнгэлийн гэх мэт өргөн цар хүрээтэй хөтөлбөрийг явуулж олон нийтийн эрх ашгийн үүднээс олон талт оролцоог хангах үүрэг хүлээх ёстой. Эдгээр олон үүргийн зарим нь ямар байх ёстой вэ гэвэл:

- Олон нийтийг мэдээллээр хангаж, олон эшт үзлийг дэлгэрүүлэхэд тус дөхөм үзүүлэхүйц хараат бус, чанартай хөтөлбөртэй байх.
- Үйл явдал, нөхцөл байдлын тухай дэлгэрэнгүй бөгөөд туйлшраагүй, алдаа мадаггүй, тэнцвэртэй нэвтрүүлэх
- Нэг талаас, өргөн олон нийтийн сонирхлыг татахуйц нэвтрүүлгүүд, нөгөө талаас нийгмийн янз бүрийн бүлэг хэсгийн эрэлт хэрэгцээг хангасан төрөлжсөн нэвтрүүлгүүд хоёрын тэнцвэрийг хангасан олон талтай хөтөлбөртэй байх.
- Улс орны бүх оршин суугчид, орон нутаг, түүний дотор хүн амын цөөнх бүлгүүдэд үйлчилж тэдэнд хүртээмжтэй байх
- Хүүхэд багачуудад шууд хандсан буюу боловсролын нэвтрүүлгүүдтэй байх
- Орон нутгийн хөтөлбөрийг дэмжих, үүний тулд орон нутагтаа болон бие даасан уран бүтээлчдийн бэлтгэсэн нэвтрүүлгийн эзлэх доод хэмжээ- квотыг тогтоож өгөх

Нэмж хэлэхэд, олон нийтийн өмнө хариуцлага хүлээдэг байх хоёр механизмыг хуулинд авч үзмээр байна. Нэгдүгээрт, олон нийтийн өргөн нэвтрүүлэг явуулдаг байгууллага нь дотооддоо гомдол барагдуулах механизмыг бий болгохыг шаардах талаар бодож үзүүштэй. Энэ нь радио, телевиз ба хэвлэл мэдээллийг бүхэлд нь хамардаг өөрийн зохицуулалтын тогтолцоог багтаасан гомдол гаргах нийтлэг үйл ажиллагаан дээр нэмэлт болох юм. Тодорхой нэвтрүүлгийг зохисгүй, худлаа гэж үзсэн хувь хүмүүс гомдол гаргаж болох бөгөөд үндэстэй бол түүнээс хүлцэл өчиж залруулж байх юм. Хоёрдугаарт, олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчдээс өөрсдийгөө олон нийтийн байнгын хараан дор, ил тод байлгахыг шаардаж болно. Жишээлбэл, Их Британид Би-Би-Си олон нийттэй хийдэг уулзалт, санал асуулгын судалгаа болон үүнтэй төстэй аргуудаар дээрх шаардлагыг хангасан зарчмуудыг нэвтрүүлсэн билээ.

Зөвлөмжүүд:

- Жилийн тайланд оруулах ёстой зарим тодорхой асуудлыг хуулинд зааж өгөх ёстой
- Олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгч байгууллагын хөтөлбөрт тавигдах шаардлагыг хуулинд илүү нарийвчлан зааж өгч болно.
- Санал гомдлыг өөрөө барагдуулах ба олон нийтийн өмнө нээлттэй байх шаардлагыг агуулсан хариуцлагын хоёр механизмыг нэмж оруулах талаар бодож үзэх хэрэгтэй.